

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЖАВХЛАНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
Нэгжийн нэр: Захиргаа удирдлагын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ: 5 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ			
Зорилт 5.1. Салбар, байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах			
1.	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;	71,4	50
2.	Салбар, байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах хуулийн төсөлд санал өгөх;	0	0
3.	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлуулж, биелэлтийг хангах, албан хаагчдад хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;	42,8	30
4.	Албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, үр чадварыг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах;	71,4	50
5.	Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлах, эрсдэлийн үнэлгээ хийх;	71,4	50
6.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах;	0	0
7.	Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар холбогдох асуудлыг шийдвэрлэх;	0	0
8.	Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Байнгын хорооны болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдаан, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах.	71,4	50
Зорилт 5.2. Хүний нөөцийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлэх, албан хаагчдыг сургалтад тогтмол хамруулах тогтолцоо бүрдүүлэх			
9.	Нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах;	71,4	50
10.	Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	71,4	50
11.	Сургалт хөгжлийн хөтөлбөр боловсруулан батлуулах;	71,4	50

12.	Албан хаагчдыг дотоодод сургалтад хамруулах;	100	70
13.	Албан хаагчдыг гадаадад сургалтад хамруулах.	100	70
Зорилт 5.3. Батлагдсан төсвийг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах			
14.	Төсвийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах;	42,8	30
15.	Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах, дүгнэлтийг хэрэгжүүлэх;	42,8	30
16.	Төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг шийдвэрлэх, бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	42,8	30
17.	Тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах;	100	70
18.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	71,4	50
Зорилт 5.4. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх;			
19.	2025 оны хамтын ажиллагааны хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах;	71,4	50
20.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээх, сурталчлан таниулах;	42,8	30
21.	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;	42,8	30
22.	Олон улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, холбогдох бусад арга хэмжээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэх;	42,8	30
23.	Байгууллагын хэмжээнд гадаад, дотоод арга хэмжээтэй холбоотой уулзалт, хурал, семинарыг зохион байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, санамж бичиг байгуулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	42,8	30
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ			
24.	Төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд сурталчлан таниулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажиллах.	0	0

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	100	15
2.	Хамтын ажиллагааны хүрээнд гадаадын сургалтад хамрагдах	100	15
3.	Эрх зүйн бакалавр зэрэг хамгаалах	100	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (7 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	6
2.	Удирдан зохион байгуулах	3,2
3.	Асуудал шийдвэрлэх	4
4.	Манлайлах	4
5.	Багаар ажиллах	4
6.	Харилцаа	4
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		4,2

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (8 хүртэл оноогоор)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	3,14
2.	Багаар ажиллах	3,29
3.	Харилцаа	3,14
Дундаж оноо		3,19

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	37,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	4,2
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	3,19
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		59,8

(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо

Үнэлгээ өгсөн:

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дарга

Төсвийн шууд захирагч



/П. Батбаатар/
2025.06.13

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Захиргаа удирдлагын газрын дарга

Нэгжийн дарга:



/Д. Жавхлан/
2025.06.13



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Сүүлийн хагас жил		
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ: 5 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ									
Зорилт 5.1. Салбар, байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр үзүүлэх, хэрэгжилтийг хангах									
1.	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;	-	Баримт бичгийн тоо	-	1	-		Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02 дугаартай албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.	100
2.	Салбар, байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах хуулийн төсөлд санал өгөх;	-	Саналын тоо	2	2	2		Төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийн жагсаалт болон бусад холбогдох баримт бичиг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх, бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагын төсөлд тус тус санал өгч холбогдох байгууллагад хүргүүлсэн.	100
3.	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлуулж, биелэлтийг хангах, албан хаагчдад	-	Батлагдах журмын тоо	-	1	-		Тус газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/106 дугаар тушаалаар "Кибер аюулгүй байдлыг хангах дотоод журам", 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар "Төрийн цахим үйлчилгээний "Хөдөлгөөнт хурдан цэг"-ийн үйл ажиллагааны журам", 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/23 дугаар тушаалаар "Цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам", 2025 оны 05 дугаар 03-ны өдрийн А/47 дугаар	100

	хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах;						тушаалаар "Цаг бүртгэлийн журам", 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/38 дугаар тушаалаар "Албан хаагчийг зайнаас болон гэрээс нь ажиллуулах үед мөрдөх журам"-ыг тус тус боловсруулж батлуулсан. Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд "Хяналт шалгалтын журам", "Бусдаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх журам", Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын үед мэдээлэл солилцох, засварлах, хариу арга хэмжээ авах, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмтэл, саатлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулах "Үндсэн болон дэмжих системийн гэмтэл, саатлын журам"-ын төслийг боловсруулсан.	
4.	Албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах;	Улсын төсөв	Үнэлгээний тоо	28	7	7	Тус газрын 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журам, 2023 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйл ажиллагааны түр журмын төслийг шинэчлэн боловсруулсан. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг олгох ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомжид үндэслэн дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: 2025 оны 01 дүгээр сард 85, 02 дугаар сард 82, 03 дугаар сард 81, 04 дүгээр сард 67, 05 дугаар сард 78, 6 дугаар сард 83, нийт 476 албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг байгуулсан. Тухайн үнэлгээний баг 138 албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулсан.	100

5.	Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлах, эрсдэлийн үнэлгээ хийх;	-	Үнэлгээний тоо	-	1	100	Тус газрын 2025 оны Алигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг 03 дугаар сарын 25-ны өдөр баталсан. Төлөвлөгөөнд нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган тайлант хугацаанд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрсдэлийн үнэлгээг 2025 оны сүүлийн хагас жилд хөндлөнгийн байгууллагаар хийхээр төлөвлөж байна.
6.	Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар холбогдох асуудлыг шийдвэрлэх;	-	Хурлын тоо	1	-	100	Өмч хамгаалах зөвлөл нь нийт 3 удаа хурал зохион байгуулсан. Хурлаар 2023 болон 2024 оны түргэн элэгдэх хөрөнгийн бүртгэлийг тулган баталгаажуулж хасалт хийхээр шийдвэрлэсэн. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн дагуу тоног төхөөрөмж, тавилга эд хөрөнгийн элэгдлийг тухай бүр санхүүгийн программд мэдээллийг шинэчлэн оруулсан.
7.	Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Байнгын хорооны болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдаан, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах.	-	Тайлангийн тоо	16	1	100	Монгол Улсын Их хурлын даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 173 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/297 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/351 дугаартай албан бичгээр үүрэг даалгаврын биелэлт хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн мэдээлэл ирүүлэх тухай 02/910 дугаар албан бичгийн хариуг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд цахим хэлбэрээр хүргүүлсэн.
Зорилт 5.2. Хүний нөөцийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлэх, албан хаагчдыг сургалтад тогтмол хамруулах тогтолцоо бүрдүүлэх							
8.	Нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах;	-	Батлагдсан хөтөлбөрийн тоо	1	1	100	Нийгмийн баталгааны хөтөлбөр нь 2026 онд шинэчлэх тул тус хөтөлбөрийн дагуу 2025 оны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан.

9.	Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	-	60	-	Монгол Улсын Засгийн газраас баталсан албан тушаалын цалингийн хэмжээг баримтлан төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээний дагуу Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд мэдээллийг шинэчлэн оруулсан. Албан хаагчдад сар бүр, хоол унааны хөнгөлөлтийг холбогдох журмын дагуу олгосон. - Хүний нөөцийн ахлах мэргэжилтний албан үүргийг хүний нөөцийн мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлэх, Дотоод үйл ажиллагааны зохион байгуулагч, няравын албан тушаалыг Нягтлан бодогчоор, Систем нэгтгэлийн хэлтсийн даргын албан тушаалыг тус хэлтсийн ахлах мэргэжилтнээр тус тус хавсран гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулсан. - Олговортой чөлөө-4 албан хаагч, олговоргүй чөлөө-1 албан хаагч, нэг удаагийн тэтгэмж-6 албан хаагчид олгосон. - Төрийн албанд ажилласан хугацаа, гаргасан амжилт зэргийг харгалзан 4 албан хаагчийг төрийн албаны тэргүүний шагналаар шагнуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. - Өмнөговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад "Нутгийн дэм" хөтөлбөрийн санхүүжилтээр хуваарилагдсан I, II улирлын олговрыг олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. - Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өмнөговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад орон нутгийн төсвөөс I, II улиралд хуваарилагдсан олговрыг олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. "Монос групп"-тэй хамтран 27 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсан. - Албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулах Спортын клуб, Жөндөрийн дэд	100
----	--	-------------	-------------------	---	----	---	--	-----

							салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан.	
							- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүнийг батлуулсан. - Ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажилласан.	
10.	Сургалт хөгжлийн хөтөлбөр боловсруулан батлуулах;			Батлагдсан хөтөлбөрийн тоо	1	-	2	Нийт албан хаагчдаас санал авч Сургалт хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулсан.
								100
								Удирдлагын академийн Ахлах түшмэлийн сургалтад-1 албан хаагч, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6 албан хаагчийг хамруулсан.
								Бусад байгууллагаас дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:
11.	Албан хаагчдыг дотоодод сургалтад хамруулах;			Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	106	168	-	- Нийгмийн даатгалын ерөнхий газрын Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нарантуяа 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сэдэвт сургалтад нийт 27 албан хаагчийг хамруулсан. - Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Бонум ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал М.Тэмүүлэнг урьж "Өөрийгөө бүтээхүй" сургалтыг зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчийг хамруулсан. - БНХАУ-ын Далянь хотын Далянь Маритайм их сургуулийн Хиймэл оюун ухааны магистрант Б.Хаш-Эрдэнийн зохион байгуулсан "Хиймэл оюун" сэдэвт сургалтад нийт 40 гаруй албан хаагчийг тус тус хамруулсан.
								100
								Жендерийн Үндэсний хорооны ажлын албаны Салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Энхжаргал 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр "Жендерийн эрх тэгш байдлыг хангах

							талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаа, анхаарах асуудал" сэдвээр жендерийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.	
12.	Албан хаагчдыг гадаадад сургалтад хамруулах.		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	12	11	11	БНХАУ-д зохион байгуулсан Азийн БРИ-ийн түнш орнуудын "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шинэчлэл ба засаглалын семинар"-т 2 албан хаагч, "Монгол Улсын төрийн удирдлагын семинар"-т 2 албан хаагч, "Хиймэл оюун ба технологийн интеграци" сургалтад 1 албан хаагч, БНЗУ-д зохион байгуулагдсан "Хиймэл оюун" сургалт, семинарт 1 албан хаагч, БНСАУ-д зохион байгуулагдсан харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр "ХУРДАН" клубийн сурагчдын аяллын хөтөлбөртэй танилцах, тус улсын туршлага солилцох, чадавхжуулах сургалтад 16 албан хаагчийг тус тус хамруулсан байна.	100
Зорилт 5.3. Батлагдсан төсвийг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах								
13.	Төсвийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах;	Улсын төсөв	Тайлангийн тоо	6	3	3	Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлж зориулалтын дагуу зарцуулан, 2025 оны 01 дүгээр сараа 06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.	100
14.	Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах, дүгнэлтийг хэрэгжүүлэх;	Улсын төсөв	Тайлангийн тоо	2	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд шаардлагатай мэдээллийг хүргүүлж Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлан хийсэн аудитын үйл ажиллагаанаас хязгаарлалттай дүгнэлт авч, ирүүлсэн зөвлөмжийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
15.	Төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний	Улсын төсөв	Худалдан авалтын тоо	11	5	5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, нэгж, албан хаагчдын	100

	гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг шийдвэрлэх, бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, тайлагнах;						саналыг үндэслэн тус газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим болон цаасан хэлбэрээр боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулсан. Тус төлөвлөгөөнд нийт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнээс 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үнэлгээний хороо байгуулан цахим системээр худалдах авах ажиллагааг зохион байгуулсан. Шууд худалдан авалтаар 10 арга хэмжээг зохион байгуулан ажилласан.					100
16.	Тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах;	Улсын төсөв	Саналын тоо	2	1	1	Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, зориулалтын дагуу зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, 2025 оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 1 удаа албан бичгээр хүргүүлсэн.					100
17.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	-	Тайлангийн тоо	12	6	6	2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим системд (shilen.gov.mn)-д санхүүгийн болон хүний нөөцийн холбогдох 68 мэдээллийг байршуулан сар бүрийн 07-ны өдрийн дотор тайланг хүргүүлж ажилласан.					100
Зорилт 5.4. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх;												
18.	2025 оны хамтын ажиллагааны хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө		Төлөвлөгөөний тоо	-	1	-	Тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан.					100

	боловсруулж батлуулах;									
19.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээх, сурталчлан таниулах;	Улсын төсөв	Мэдээ, мэдээллийн тоо	40	20	20			Байгууллагын албан ёсны олон нийтийн сүлжээ (фэйсбүүк пэйж)-ээр байгууллагын үйл ажиллагаа, "ХУРДАН" цэг, киоск машин, "ХУРДАН" клубийн үйл ажиллагаа, Бүх нийтийн цахим ур чадвар дээшлүүлэх сургалт, Нийтийн мэдээллийн ил тод shilen.gov.mn системийг олон нийтэд сурталчлах зорилгоор нийт 370 видео мэдээ, контент, фото мэдээ, постер зэрэг мэдээ, мэдээллийг бэлтгэн хүн, хуулийн этгээдэд түгээн ажилласан.	100
20.	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;	-	Байгууллагын тоо	-	3	2			Сонгинохайрхан дүүрэгт "ХУРДАН" цэгийн үйлчилгээ нэвтэрсэн тухай мэдээллийг МҮОНТ, ТВ9, Тэнгэр телевиз, Малчин телевиз, gogo.mn, zugii.mn зэрэг хэвлэл мэдээллийн 6 байгууллага; Төрийн банктай хамтран Төрийн банкны киоск машинд "ХУРДАН" цэгийн үйлчилгээг нэвтрүүлэхэд хамтран ажиллах санамж бичиг үзэглэх арга хэмжээг МҮОНТ, Eagle телевиз, NTV телевиз, news.mn, duuren.life.mn, time.mn, tug.mn, 24 tsag.mn, ikon.mn зэрэг хэвлэл мэдээллийн 9 байгууллага; Нийтийн мэдээллийн ил тод shilen.gov.mn системийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Чанар хяналтын газрын Ахлах мэргэжилтнийг МҮОНТ, Eagle телевизийн зочны цаг нэвтрүүлэгт оролцуулах ажлыг зохион байгуулсан.	100
21.	Олон улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, холбогдох бусад арга хэмжээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэх;	Улсын төсөв	Сургалтад хамрагдах албан хаагчийн тоо	-	1	1			Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Худалдаа, эдийн засгийн газартай хамтран байгууллагын 5 албан хаагчийг дараах сургалтын агуулгын хүрээнд семинарт хамруулсан. Үүнд: • 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шинэчлэл ба засаглал" – 2 албан хаагч;	100

22.	Байгууллагын хэмжээнд гадаад, дотоод арга	Улсын төсөв	Арга хэмжээний тоо	-	2	2	• 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн цахим худалдаа" – 1 албан хаагч; • 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Цахим худалдаа" – 2 албан хаагч; • Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Технологи, эдийн засгийн хамтын ажиллагааны программын хүрээнд 2 албан хаагчийг семинарт хамруулсан. • 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "IoT мэдээлэл технологийн чиглэлд мэргэшүүлэх сургалт" – 1 албан хаагч • 2025 оны 06 дугаар сард зохион байгуулагдах "Хиймэл оюун" сургалт – 1 албан хаагч Олон улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Канвон мужид мэдээлэл технологийн чиглэлээр богино хэмжээний сургалтад 13 албан хаагчийг үе шаттайгаар хамруулсан. Унгар Улстай байгууллагын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлд сургалтад хамруулахаар хамтран ажиллах албан бичгийг боловсруулан хүргүүлж холбогдох шатны уулзалтыг зохион байгуулсан. Бүгд Найрамдах Казахстан Улсын "Үндэсний мэдээллийн технологи" ХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд байгууллагын албан хаагчдыг "Хиймэл оюун", "Ухаалаг хот", "Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл" агуулгын хүрээнд 12 албан хаагчийг сургалтад хамруулахаар мэдээлэл хүргүүлсэн.	Байгууллагын хэмжээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор:	100
-----	---	-------------	--------------------	---	---	---	---	---	-----

	хэмжээтэй холбоотой уулзалт, хурал, семинарыг зохион байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, санамж бичиг байгуулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх							- Бүгд Найрамдах Казахстан Улсын "Үндэсний мэдээллийн технологи" ХК, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Худалдаа, эдийн засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Соёлын хэлтэс, Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Австрали Улсын Процессын дахин инженерчлэлийн судлаач М.Хабе, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан, Дэлхийн банк, "Канад-Монголын Мерит" төслийн Каталист Плас байгууллага зэрэг 9 байгууллагатай хамтран ажилласан. - Байгууллагын хэмжээнд дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор: - Монголын зуслангуудын холбоо, Монголын ахмадын холбоо, Ай Си Ти групп ХК, Мобиком корпораци ХХК, Хаан банк ХК, Төрийн банк ХК, Капитрон банк ХК, Гэрэгз Системс ХХК, Эмпасофт Технологийн Сургууль, Геганэт ХХК, Хайнд Про ХХК, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Боловсролын газар зэрэг 14 байгууллагатай хамтран ажилласан.
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ								
23. Төрийн цахим үйлчилгээг хуулийн этгээдэд сурталчлан таниулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн ажиллах.	Улсын төсөв	Арга хэмжээний тоо	1	1	1			"Зүүн бүсийн харилцаа холбоо, мэдээлэл технологийн чуулган"-ыг зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамруулан дэмжлэг үзүүлж ажилласан. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хүрээнд төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэг нийслэлийн 9 дүүрэг, 3 аймагт хуваарь гарган ажиллаж хүн, хуулийн этгээдэд 3,000 үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан.

									"UB FOOD фестиваль 2025" арга хэмжээнд төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэг нь 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 14-ний өдрүүдэд Сүхбаатарын талбайд байршуулж 83 үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. "Монгол хүүхэд 2025" хүүхдийн баярын арга хэмжээнд төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэг талбайд байршуулж хүн, хуулийн этгээд төрийн цахим үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2025 оны 5 дугаар сарын 15-нд зохион байгуулсан "Гараас гарт" нээлттэй хаалганы өдөрлөг, ШУТИС-ийн харьяа Мэдээлэл холбоо, технологийн сургуулиас 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Ажил олгогчдын өдөрлөг" арга хэмжээнд оролцож байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Ability Expo" цогц арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулагдаж Говийн бүсийн төрийн албан хаагчдад цахим ур чадвар дээшлүүлэх сургалт зохион байгуулахад үзүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Дархан-Уул аймагт зохион байгуулагдах "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" төвийн бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Өмнөговь аймагт "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" говийн бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан.
--	--	--	--	--	--	--	--	--	---

мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1.	Байгууллагаас байгуулсан зохион сургалтад хамрагдах	Сургалтын тоо	-	1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нарантуяа 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сэдэвт сургалтад хамрагдсан. Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Бонум ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал М.Тэмүүлэнг урьж "Өөрийгөө бүтээхүй" сургалтад хамрагдсан. БНХАУ-ын Далянь хотын Далянь Маритайм их сургуулийн Хиймэл оюун ухааны магистрант Б.Хаш-Эрдэнийн зохион байгуулсан "Хиймэл оюун" сэдэвт сургалтад хамрагдсан. Жендерийн Үндэсний хорооны ажлын албаны Салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Энхжаргал 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр "Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаа, анхаарах асуудал" сэдвээр жендерийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.	01-06	100
2.	Хамтын ажиллагааны хүрээнд гадаадын сургалтад хамрагдах	Сургалтын тоо	-	1	БНХАУ-д зохион байгуулсан Азийн БРИ-ийн түнш орнуудын "Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн шинэчлэл ба засаглалын семинар"-т хамрагдсан.	02	100
3.	Эрх зүйн бакалавр зэрэг хамгаалах	Сургалтын тоо	-	1	Их Засаг Олон улсын сургуулийг 2025 оны 01 дүгээр сард Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан.	01	100

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга

Тайлагнасан:

Захиргаа удирдлагын газрын дарга



П. Батбаатар/

2025.06.25

18:19

/Д. Жавхлан/